

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанхус сумын Согоог хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2022/99/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn “Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор: В.Хуандых Утас: 99426960 Цахим хаяг: khuash69@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	Error! Bookmark not defined.
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа.....	18
4.2 Төлбөрийн акт.....	19
Байхгүй	19
4.3 Албан шаардлага	19
4.4 Зөвлөмж	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өмнө, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

УЛААНХУС СУМЫН СОГООГ
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Б.МАНЧУК ТАНАА

Б0022.08-85 № 162
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанхус сумын Согоог цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанхус сумын Согоог хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Dugnelt-TA

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



Dugnelt-TA

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>83495301.11</u>	<u>56592838.95</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	549710.00	0.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	549710.00	0.00
31110	Төгрөг	549710.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	82945591.11	56592838.95
351	Түүхий эд материал	43600.00	373900.00
35110	Тусгай зориулалттай материал	0.00	0.00
35130	Эм боох материал	43600.00	373900.00
354	Хангамжийн материал	82901991.11	56218938.95
35410	Бичиг хэргийн материал	515510.00	17000.00
35420	Аж ахуйн материал	24595860.00	22689860.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1.50	0.00
35440	Түлш, шатах тослох материал	107840.00	2671645.00
35450	Барилгын засварын материал	0.00	0.00
35460	Хүнсний материал	33616036.61	6773690.95
35470	Бусад хангамжийн материал	24066743.00	24066743.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>652041246.73</u>	<u>636712333.25</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	652041246.73	636712333.25
391	Газар	0.00	0.00
392	Биет хөрөнгө	644391246.73	629107333.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	623855089.16	623855089.16
39202	Хуримтлагдсан элэгдэл	-14742664.08	-27741745.64
39203	Авто-тээврийн хэрэгсэл	9000000.00	9000000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-6000000.00	-9000000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	18289050.00	26903700.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-5450149.88	-10278675.40
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25878156.00	26628156.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12615955.72	-15485005.76
39214	Бусад үндсэн хөрөнгө	12334163.00	12334163.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-9716421.75	-10668328.11
39216	Дуусаагүй барилга, байгууламж	0.00	0.00
39217	Ном	3559980.00	3559980.00
393	Биет бус хөрөнгө	7650000.00	7605000.00
39301	Програм хангамж	575000.00	575000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-305000.00	-350000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	7380000.00	7380000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	<u>735536547.84</u>	<u>693305172.20</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>5921544.00</u>	<u>3707470.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5921544.00	3707470.00
413	Өглөг	5921544.00	3707470.00

41310	Ажилчидтай холбогдсон өглөг	3168774.00	0.00
4136	Бусад өглөг	2752770.00	3707470.00
41361	Байгууллагад төлөх өглөг	2752770.00	3707470.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>729615003.84</u>	<u>689597702.20</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	729615003.84	689597702.20
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	41723775.00	41723775.00
51101	Өмч: - төрийн	41723775.00	41723775.00
512	Хуримтлагдсан үр дүн	632684062.68	592666761.04
51210	Өмнөх үеийн үр дүн	632684062.68	632684062.68
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	-40017301.64
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	55207166.16	55207166.16
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>735536547.84</u>	<u>693305172.20</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	347,007,573.00	326,373,290.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,483,580.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	6,483,580.00	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	6,483,580.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,483,580.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	340,523,993.00	326,373,290.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	321,898,400.00	316,599,290.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	10,395,900.00	1,270,290.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	-	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	311,502,500.00	315,329,000.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	-	-
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	-	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	205,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	205,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	9,412,900.00	9,569,000.00

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	9,412,900.00	9,569,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	9,212,693.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	9,212,693.00	
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	-
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	-	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	343,385,778.48	366,390,591.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	343,385,778.48	366,390,591.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	333,519,385.48	366,123,472.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	252,068,997.00	258,346,606.54
210101	Үндсэн цалин	223,555,097.00	231,357,864.54
210102	Нэмэгдэл	-	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-
210104	Урамшуулал	20,318,500.00	18,793,342.00
210105	Гэрээт ажлын хөлс	8,195,400.00	8,195,400.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,344,000.00	35,339,500.00
210201	Тэтгэврийн даатгал	24,168,000.00	24,868,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,544,000.00	2,617,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,035,200.00	2,094,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	508,800.00	523,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,088,000.00	5,235,500.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	-	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,318,010.00	8,032,695.00
210301	Гэрэл, цахилгаан	1,560,070.00	1,892,500.00
210302	Түлш, халаалт	9,757,940.00	6,140,195.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,510,290.00	4,066,511.50
210401	Бичиг хэрэг	529,700.00	986,510.00
210402	Тээвэр, шатахуун	873,440.00	333,501.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	375,000.00	468,000.00

210404	Ном, хэвлэл	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	732,150.00	2,278,500.00
2105	Нормативт зардал	12,520,160.00	34,514,495.66
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	222,200.00	97,500.00
210502	Хоол, хүнс	12,297,960.00	32,806,595.66
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,610,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	405,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	-
210602	Тавилга	-	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-
210604	Урсгал засвар	-	405,000.00
2107	Томилолт, зочны зардал	104,600.00	279,000.00
210701	Гадаад албан томилолт	-	-
210702	Дотоод албан томилолт	104,600.00	279,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	500,000.00	446,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	200,000.00	196,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,153,328.48	24,693,563.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	745,740.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,407,588.48	24,693,563.48
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,866,393.00	267,119.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,212,693.00	-
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	9,212,693.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	267,119.46
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	-
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	267,119.46

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	653,700.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	653,700.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	3,621,794.52	(40,017,301.64)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	3,621,794.52	(40,017,301.64)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	41,723,775.00	55,207,166.16	632,684,062.68	729,615,003.84
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	41,723,775.00	55,207,166.16	632,684,062.68	729,615,003.84
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	41,723,775.00	55,207,166.16	632,684,062.68	729,615,003.84
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	41,723,775.00	55,207,166.16	632,684,062.68	729,615,003.84
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	41,723,775.00	55,207,166.16	632,684,062.68	729,615,003.84
D08	Тайлант үеийн үр дүн			-40,017,301.64	-40,017,301.64
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	41,723,775.00	55,207,166.16	592,666,761.04	689,597,702.20

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	330128093.00	325103000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	330128093.00	325103000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	311502500.00	315329000.00

131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	311502500.00	315329000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	205000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	205000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	9412900.00	9569000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	9412900.00	9569000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	9212693.00	0.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	9212693.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>329546983.00</u>	<u>322367000.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	329546983.00	322367000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	319680590.00	322099880.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	250049790.00	261515380.54
210101	Үндсэн цалин	221535890.00	234526638.54
210102	Нэмэгдэл		
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	20318500.00	18793342.00
210105	Гэрээт ажлын хөлс	8195400.00	8195400.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34344000.00	35339500.00
210201	Тэтгэврийн даатгал	24168000.00	24868600.00
210202	Тэтгэмжийн даатгал	2544000.00	2617700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2035200.00	2094200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	508800.00	523500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5088000.00	5235500.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9402700.00	9359000.00
210301	Гэрэл, цахилгаан	1415470.00	1892500.00
210302	Түлш, халаалт	7987230.00	7466500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2816500.00	2925000.00
210401	Бичиг хэрэг	523100.00	279000.00
210402	Тээвэр, шатахуун	666400.00	416300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	375000.00	468000.00
210404	Ном, хэвлэл	31400.00	62800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		205000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1220600.00	1493900.00
2105	Нормативт зардал	21355000.00	11515600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	174400.00	255800.00
210502	Хоол, хүнс	20526600.00	10806400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	654000.00	453400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	210000.00
210604	Урсгал засвар	0.00	210000.00

2107	Томилолт, зочны зардал	104600.00	279000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	104600.00	279000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	300000.00	810100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	560100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300000.00	250000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1308000.00	146300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1308000.00	146300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9866393.00	267119.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	9212693.00	0.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	9212693.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	267119.46
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	267119.46
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	653700.00	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	653700.00	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>581110.00</u>	<u>2736000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	31400.00	3285710.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	31400.00	3285710.00
2200	Дотоод эх үүсвэрээр	31400.00	3285710.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	31400.00	3285710.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-31400.00</u>	<u>-3285710.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>0.00</u>	<u>0.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	549710.00	-549710.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	549710.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	549710.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	324,898,000.00	325,180,590.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	324,898,000.00	325,180,590.54

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	324,898,000.00	325,180,590.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	261,774,000.00	261,515,380.54
210101	Үндсэн цалин	234,783,200.00	234,526,638.54
210102	Нэмэгдэл		
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	18,795,400.00	18,793,342.00
210105	Гэрээт ажлын хөлс	8,195,400.00	8,195,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,339,500.00	35,339,500.00
210201	Тэтгэврийн даатгал	24,868,600.00	24,868,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,617,700.00	2,617,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,094,200.00	2,094,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	523,500.00	523,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,235,500.00	5,235,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,359,000.00	9,359,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,892,500.00	1,892,500.00
210302	Түлш, халаалт	7,466,500.00	7,466,500.00
210303	Цэвэр, бохир ус		
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	2,720,000.00	2,720,000.00
210401	Бичиг хэрэг	279,000.00	279,000.00
210402	Тээвэр, шатахуун	416,300.00	416,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	468,000.00	468,000.00
210404	Ном, хэвлэл	62,800.00	62,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,493,900.00	1,493,900.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2105	Нормативт зардал	11,515,600.00	11,515,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	255,800.00	255,800.00
210502	Хоол, хүнс	10,806,400.00	10,806,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	453,400.00	453,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	210,000.00	210,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	210,000.00	210,000.00
2107	Томилолт, зочны зардал	279,000.00	279,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	279,000.00	279,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,654,600.00	2,646,100.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,404,600.00	2,396,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,046,300.00	1,596,010.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,046,300.00	1,596,010.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	324,898,000.00	324,630,880.54
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	315,329,000.00	315,061,880.54
131001	Улсын төсвөөс санхүүжих		
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	315,329,000.00	315,061,880.54
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих		
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	9,569,000.00	9,569,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	9,569,000.00	9,569,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		549710.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26.00	30.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	12.00
620004	Гэрээт ажилтан	2.00	4.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	125.00	125.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	125.00	125.00
630001	Төрийн өмчит ЕБС	125.00	125.00
630002	Хувийн ЕБС		
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	0.00	0.00
632	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	0.00	0.00
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	0.00	0.00
640003	Хувийн эмнэлгээр эмчлүүлэгсдийн тоо		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	26.0	30.0
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	13.00	13.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11.00	13.00
650010	Гэрээт ажилтан	2.00	4.00

650011	Улс төрийн албан хаагч (УТ)		
--------	-----------------------------	--	--

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	205000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	205000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	205000.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	205000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		205000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	205000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	205000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл		
131103	ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		205000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		
131106	Төсвийн урамшуулал		
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаанхус сумын Согоог хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Нурлан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар хэрэгжүүлсэн.

Улаанхус сумын Согоог хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Улаанхус сумын Согоог хүүхдийн цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол олгох чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус цэцэрлэг нь 2021 оны хичээлийн жилд "Хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах" гэсэн зорилготой ажиллаж, дараах үндсэн 3 дэд зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- ❖ Бага насны хүүхдийн бие бялдар, эрүүл мэнд, хэл яриа, харилцаа, гоо зүйн мэдрэмжийг хөгжүүлэх
- ❖ Хүүхэд бүрийн онцлог, ялгаатай хэрэгцээнд тулгуурлан сурах, хөгжих үйлийг дэмжих хичээл, сургалтын үйл ажиллагаанд тэдний оролцоог тэгш хангах, хамтран суралцах соёлыг төлөвшүүлэх
- ❖ Дижитал технологийг хичээл, сургалтын үйл ажиллагааны үндсэн хэрэгсэл болгон хөгжүүлэх, түүнийг үр дүнтэй ашиглахад багш нарын мэргэжлийн бүлгийн үйл ажиллагааг чиглүүлж багш ажлын байрандаа тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн Төсвийн ерөнхийлөгчийн дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2019-2020 оны үйл ажиллагаанд шалгалт хийсэн байна.

Цэцэрлэг нь дотоод хяналтын нэгжгүй боловч эрхлэгчийн тушаалаар батлагдсан журам, зааврын дагуу төлөвлөгөөт дотоод хяналт шалгалт хийдэг байна. Тус сургуулийн дотоод хяналтын талаар ойлголт олж авснаар дотоод аудитаас туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаанхус сумын Согоог хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 335.3 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 3.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 60 хувиар буюу 2.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Улаанхус сумын Согоог хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 37.9 сая төгрөгөөр буюу 4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	549.7	0.00	-549.7
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	82945.6	56592.8	-26352.8
Үндсэн хөрөнгө	652041.2	636712.3	-15328.9
Нийт хөрөнгө	<u>735536.5</u>	<u>693305.2</u>	<u>-42231.3</u>
Өр төлбөр	5921.5	3707.5	-2214.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	729615.0	689597.7	-40017.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	<u>735536.5</u>	<u>693305.2</u>	<u>-42231.3</u>

Мөнгөн хөрөнгө данс 0.5 сая төгрөгөөр буурсан нь банкинд дахь дансны оны эхний үлдэгдлийг зарцуулсантай холбоотой. Авлага данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

Бараа материал дансны үлдэгдэл 56.6 сая төгрөг болж 26.3 сая төгрөгөөр буурсан хүнсний материалын үлдэгдэл буурснаас шалтгаалжээ. Тайлант онд 22.6 сая төгрөгийн материал худалдан авч, 19.8 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Хүнсний материалын данснаас 29.0 сая төгрөгийн материалыг хасаж үүнээс 4.8 сая төгрөгийг үндсэн хөрөнгөд шилжүүлж, 22.3 сая төгрөгийг зардалд бичсэн байна.

Энэ нь өмнөх оны аудитаар хүнсний материалын тооллогоор илэрсэн 33.6 сая төгрөгийн зөрчлийн мөрөөр өмнөх жилүүдэд хоолны зардлын төсвөөс зохих

зөвшөөрөлгүйгээр хөрөнгө худалдан авсан, бусад зардалд зарцуулсныг хүнсний үлдэгдлээр бүртгэж ирсэн зөрчлийг залруулсантай холбоотой байна.

Хүнсний материалын дансанд оны эхэнд 33.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба 10.6 сая төгрөгийн хүнс худалдан авч, 8.4 сая төгрөгийн материалыг зарцуулж 29.4 сая төгрөгийн материалыг дээрх байдлаар хасаж жилийн эцэст 6.7 сая төгрөгийн хүнсний материалын үлдэгдэлтэй гарсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 636.7 сая төгрөг болж 15.3 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд үндсэн хөрөнгийн данс төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 3.3 сая, үнэгүй хүлээн авсан 1.3 сая, бараа материалаас шилжүүлсэн 4.8 сая нийт 9.4 сая төгрөгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгөнд 24.7 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 689.6 сая төгрөг болж 40.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 326.4 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 20.6 сая төгрөгөөр буюу 5.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй орлого байна.

Нийт зардал 371.2 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 27.8 сая төгрөгөөр буюу 8.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан норматив зардал, бусад бараа үйлчилгээний зардал байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд бараа материал данснаас үндсэн хөрөнгөд шилжүүлсэн 4.8 сая төгрөгтэй холбоотой нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдлээ

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Улаанхус сумын Согоог хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны анх батлагдсан төсөв 350.5 сая төгрөг, тодотгосон төсөв 324.9 сая төгрөг байна.

Тодотгосон төсөв нь анх баталсан төсвөөс 25.6 сая төгрөгөөр буурсан байна. Үүнд: Цалин хөлсний зардлыг 3.1 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 0.4 сая төгрөгөөр, хангамж материалын зардал 0.5 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 2.3 сая төгрөгөөр нэмэгдэж, хоолны зардлыг 35.5 сая төгрөгөөр анх баталснаас бууруулж тодотгосон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Улаанхус сумын Согоог хүүхдийн цэцэрлэг нь тайлант онд 324.9 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 324.6 сая төгрөгийг зарцуулж, цалин, бусад зардлын хэмнэлтээс 0.3 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 450.4 сая төгрөг буюу 100.1 хувьтай байна. Энэ нь арилжааны банкин дахь үлдэгдэл 0.5 сая төгрөгийг зарцуулсан тай холбоотой байна.

Нийт төсвийн 80.4 хувийг цалин, 10.9 хувийг НДШ-ийн зардал, 2.9 хувийг тогтмол зардал, 0.8 хувийг хангамж бараа материалын зардал, 3.5 хувийг норматив зардал, 1.5 хувийг бараа үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 0.2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авч бага үнэтэй түргэн элэгдэх зардалд 0.2 сая төгрөг зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлогыг төвлөрүүлээгүй байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Улаанхус сумын Согоог хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Улаанхус сумын Согоог хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны төсөвт дүн шинжилгээ хийж үзэхэд үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай цалингийн зардалд 261.5 сая төгрөг, НДШ-ийн зардалд 35.3 сая төгрөг, тогтмол зардалд 9.3 сая төгрөг, хоолны зардалд 10.8 сая төгрөг нийтдээ 316.9 сая төгрөг зарцуулсан байна.

Төсвийн гүйцэтгэл нийт 324.9 сая төгрөгөөс үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай зардлыг хасахад 8.0 сая төгрөгийн зардлыг тэвчиж болох зардал гэж үзээд тогтоолын дагуу 0.8 сая төгрөгийг хэмнэх тооцоо гарч байгаа ба 2021 онд төсвөөс хэмнэлт 0.3 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж, оны эхний үлдэгдэл 0.5 сая төгрөгийг зарцуулсан тул Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолын хэрэгжилт бүрэн хангагдаагүй гэж үзлээ.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэхүйц асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Улаанхус сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 онд нийт 325.2 сая төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 116 мэдээллийг хугацаандаа байршуулж, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 137.6 төгрөгийг мэдээлж, 187.6 сая төгрөгийн гүйлгээний мэдээлэл болон 3.7 сая төгрөгийн өр үүсгэсэн 1 мэдээллийг мэдээлээгүй, 2 мэдээллийг буюу 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт байршуулах хугацаа болоогүй байна. Шилэн дансны хуулийн хэрэгжилт 89.5 хувьтай байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар хүнсний материалын хадгалалт хамгаалалтай холбоотой 1 зөвлөмж, авлага, өглөг, бараа материалын бүртгэл, тооллоготой холбоотой 82.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөгдсөн байна. Давтан шалгаж үзэхэд албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж, зөрчлийг давтан гаргаагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар бараа материалын бүртгэл, тооллоготой холбоотой асуудалд анхаарах шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийтдээ 27.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 4.8 сая төгрөгийн алдааг залруулж, 22.8 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага өгч, шилэн данстай холбоотой зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Бараа материал данснаас үндсэн хөрөнгөд шилжүүлсэн 4.8 сая төгрөгийн залруулах бичилт хийхдээ үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэж тайлант үеийн орлогыг нэмэгдүүлснийг зардал бууруулж залрууллаа.

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.3 Албан шаардлага

Аудитаар 22.8 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил илэрч зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Өмнөх оны аудитаар хүнсний материалын тооллогоор илэрсэн 33.6 сая төгрөгийн зөрчлийн мөрөөр хүнсний материалын данснаас 29.0 сая төгрөгийн материалыг хасаж үүнээс 4.8 сая төгрөгийг үндсэн хөрөнгөд шилжүүлж, 22.3 сая төгрөгийг зардалд бичихдээ бүрдүүлсэн материалын үнэн зөвийг сумын санхүүгийн албаар хянаж баталгаажуулаагүй, бараа материал данснаас зарлага гаргах тухай тушаал шийдвэр гаргаж албажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 5 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн зарчим, 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-д “үнэн зөв байх, 13 дугаар зүйлийн, 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хүнсний материалын данснаас үйл ажиллагаанд зарцуулсан гэх 22.3 сая төгрөгийн анхан шатны баримтуудын бүрдүүлэлтийг дахин хянаж, албажуулан баримтжуулж зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүллээ.

2. Улаанхус сумын Согоог хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны төсөвт дүн шинжилгээ хийж үзэхэд үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай цалингийн зардалд 261.5 сая төгрөг, НДШ-ийн зардалд 35.3 сая төгрөг, тогтмол зардалд 9.3 сая төгрөг, хоолны зардалд 10.8 сая төгрөг нийтдээ 316.9 сая төгрөг зарцуулсан байна.

Төсвийн гүйцэтгэл нийт 324.9 сая төгрөгөөс үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай зардлыг хасахад 8.0 сая төгрөгийн зардлыг тэвчиж болох зардал гэж үзээд тогтоолын дагуу 0.8 сая төгрөгийг хэмнэх тооцоо гарч байгаа ба 2021 онд төсвөөс хэмнэлт 0.3 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж, оны эхний үлдэгдэл 0.5 сая төгрөгийг зарцуулсан тул Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолын хэрэгжилт бүрэн хангагдаагүй гэж үзлээ.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах талаар албан шаардлага хүргүүллээ.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Улаанхус сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 онд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 187.6 сая төгрөгийн гүйлгээний мэдээлэл болон 3.7 сая төгрөгийн өр үүсгэсэн талаарх 1 мэдээллийг мэдээлээгүй байна. Шилэн дансны хуулийн хэрэгжилт 89.5 хувьтай байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасныг мөрдөж цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, 6.4.8-д заасныг мөрдөж төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг тухай бүр мэдээлж, шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Улаанхус сумын Согоог хүүхдийн цэцэрлэг	3	210.4					2	22.8	1	187.6